

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 07 өдөр

Дугаар A/25

Даланзадгад сум

┌ Дархлаажуулалтыг эрчимжүүлэх арга ┐
хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Засгийн газрын 2023 оны "Дархлаажуулалтын үндэсний товлалыг шинэчлэн батлах тухай" 472 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2024 оны "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай" 455 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинжуулалтын хамралтыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг "Дархлаажуулалтыг хүн бүрт" уриан дор аймгийн хэмжээнд 2025 оны 05 дугаар сарын 05-30-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинжуулалтыг эрчимжүүлэх сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахтай холбоотой 16,714,600 (арван зургаан сая долоон зуун арван дөрвөн мянга зургаан зуу) төгрөгийн зардлыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирлын баталсан "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын удирдамж"-ийн дагуу зарцуулахыг байгууллагын Ерөнхий нягтлан бодогч (Б.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3.Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинжуулалтын сургалт, нөлөөллийн ажлыг аймгийн хэмжээнд удирдлага арга зүйгээр ханган үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв (Б.Амгалан)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Б.Цагаанцэнд)-д даалгасугай.

ДАРГА

Ц.ЖАВЗАНДУЛАМ



462501165

